

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Судалгаатай хөгжил


Ойн баялаг- бидний ирээдүй

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2013. 07 сар. №14 (048)

www.mongolianeconomy.mn

“ЭРЭЭН” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Монгол үнээний цэвэр сүү

Миний Монголын СҮҮ



ҮНДЭСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР
"СҮҮ" ХУВЬЦААТ КОМПАНИ

.. Эрүүл урт удаан
наслах амьдрахуйн
нууцад нэвтрэх аялал
минь үрэлжилсээр ..

Хүмүүний эрүүл
оршихуйн эх үндэс нь
төрт өссөн нутаг, ус
алаар, газар шороо
түүнд зохицон бий
болсон хоол хүнс
билээ.

ҮНДЭСНИЙ

Ундаа



Утас: 631950 • www.mongolmilk.mn
 www.facebook.com/mongolmilk.mn

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ:



ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

**МОНГОЛЫН
ТАВИЛАГЫН ХОЛБОО**

ТАВИЛАГА

ЕКХРО 2013

МИШЭЭЛ ЭКСПОД 7.5-22

СУГАЛААТАЙ, УРАМШУУЛАЛТАЙ, ХЯМДРАЛТАЙ ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА



МӨРӨӨДЛИЙН ГЭР

ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

Өдөр бүр



УТАС: 91914805



Ногоон хөгжлийн шалтгаал

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
ОРЧУУЛАГЧ:

Теренс Эдвардс
Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж глаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

“Mongolian Economy” сэтгүүлийн захиалгын үнэ

Нэг дугаарын үнэ	1	15.000₮	10\$
Улирлаар	6	90.000	60\$
Хагас жилээр	12	180.000₮	120\$
Бүтэн жилээр	24	360.000₮	240\$

Борлуулалтын үнэ: 18.000₮

Хэвлэл захиалгын компаниуд:

“Монгол шуудан” ХХК

“Улаанбаатар шуудан” ХХК

“Түгээмэл шуурхай шуудан” ХХК

“Скай шуудан” ХХК

The Morning Post

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД ЗАХИАЛГА БАЙНГА АВЧ БАЙНА



“Mongolian Economy” сэтгүүлийн зар, сурталчилгааны үнэ

A4 буюу сэтгүүлийн 1 нүүр	800.000₮
A3 буюу сэтгүүлийн дэлгэмэл нүүр	1.600.000₮
A5 буюу сэтгүүлийн 1/2	400.000₮
A6 буюу сэтгүүлийн 1/4	200.000₮
Сэтгүүлийн 1/3	300.000₮

Зар/төсөл, тендер, ажлын байрны зар/

A4 буюу сэтгүүлийн 1 нүүр	320.000₮
A4 хуудсын 1/2	160.000₮
A4 хуудсын 1/4	80.000₮

II-V нүүр	1.200.000₮
Хавтасны анонс	800.000₮

АЯЛАЛЖУУЛЧЛАЛ

8 “Эрээн” аялал жуулчлал

10 Мэдлэгт суурилсан байх тусмаа үүргэвчтэй аялагчид цөөрнө

12 Бүтээлч үйлдвэрлэл

16 Тэнэглэлийн марш

ЭДИЙН ЗАСАГ

20 Судалгаатай хөгжил

23 Ж.Жамъянтив: Завханы ирээдүй ногоон хөгжлийн загвар аймаг болох



27 Урт настай хөрөнгө оруулалт

29 Ажил олгогч, ажилтны хоорондох гэрээ

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

31 Ойн баялаг- бидний ирээдүй

МОНГОЛД



Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар 2014 онд Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж чадвал инфляцийн түвшинг зургаан хувьтай байлгах боломжтой гэжээ. Засгийн газраас инфляцийн түвшинг бууруулж, тогтворжуулах бодлого баримтлах бөгөөд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжиж, барилгын материалын импортыг бууруулж, дотоодод үйлдвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны Засгийн газрын хувь нийлүүлсэн хөрөнгийг 200 сая ам.доллартай тэнцэх

хэмжээний төгрөгт хүргэн нэмэгдүүлэхээр боллоо. Цаашид шаардлагатай эх үүсвэрийг жил бүр улсын төсөвт тусгаж байх юм. Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 2011 онд 33 тэрбум, 2012 онд 23.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмжээ.

Арьс, ширний үйлдвэрүүдийн цогцолборыг Дархан-Уул аймагт төвлөрүүлэн байршуулах, үйлдвэрүүдэд технологийн шинэчлэл хийх, дэд бүтэц байгуулахад Чингис бондын хөрөнгөөс санхүүжилт олгохоор боллоо. Улсын хэмжээнд арьс шир боловсруулдаг 35 үйлдвэр, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 170 гаруй үйлдвэр ажиллаж байгаа ч жилд бэлтгэгддэг 10.3 сая ширхэг арьс ширний 25.8 хувийг л үндэсний үйлдвэрлэгчид боловсруулж байна.

Төрийн орон сууцны корпораци (ТОСК) 100

хувь төрийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулах Засгийн газрын шийдвэр гаргалаа. Ерөнхий сайдын шууд харъяанд ажиллах тус байгууллага нь Засгийн газраас иргэдээ орон сууцжуулах хөтөлбөрийнхөө хоёр дахь хэсгийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх аж.



Монгол Улсын Засгийн газар Германы технологи ашиглан нүүрс шингэрүүлж бензин гаргах ажлыг эхлүүлж, хариуцсан төслийн нэгж байгуулахаар тогтсон. Уг төслийг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийн үүсгэл санаачилгад тулгуурлах аж. Гэхдээ шатахуун нь стратегийн бүтээгдэхүүн учраас үйлдвэрийн тодорхой хэсгийг төр эзэмших нь зүйтэй гэж үзэн төрийн эзэмшлийн хувийг 51 байхаар тогтжээ. Мөн иргэдийн оролцоо, ил

тод бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Монголын хөрөнгийн биржээр тодорхой хэмжээний хувьцааг арилжих юм.

Тулгар төр байгуулагдсаны 2222 жилийн ой, Их Монгол Улс байгуулагдсаны 807, Ардын хувьсгалын 92 жилийн ойн үндэсний баяр наадам энэ сарын 11, 12, 13-ний өдрүүдэд өргөн дэлгэр болж өндөрлөлөө. Монгол түмний их баяр цэнгэл болсон үндэсний баяр наадмын босгон дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшиж, ялалт байгуулсан Цахиагийн Элбэгдоржийн тангараг өргөх ёслол нийслэлийн төв талбайд боллоо. Өнөө жилийн улсын наадамд нийтдээ 1.7 тэрбум төгрөг зарцуулсан юм.



2013 оны үндсэн үзүүлэлтийн таамаг

Үзүүлэлт	2012*	2013**
ДНБ-ийн өсөлт, хувь	12.7	10-17
Инфляци, хувь	15	10
Зээлийн хүү, хувь	18	18
USD/MNT, оны эцэст	1350	1250
Чанаргүй зээлийн хэмжээ, хувь	4.7	8

*2012 оны гүйцэтгэлийн урьдчилсан таамаг
**2013 оны таамаг

Уг таамаг, төсөөлллийг ашиглан дүгнэхэд 2013 онд эдийн засгийн эрүүл мэндийн үзүүлэлт дараах байдалтай гарах магадлалтай байна.



Эх сурвалж: Purplebook.mn

ДЭЛХИЙ ДАХИНД



Хоёр Солонгосын “Каэсон” үйлдвэрлэлийн бүсийг дахин нээх хэлэлцээр амжилттай болжов. Уг хэлэлцээрийн хүрээнд “Каэсон” бүсэд үйл ажиллагаа явуулж байсан Өмнөд Солонгосын компаниуд эзгүй орхисон бүтээгдэхүүндээ шалгалт хийхээр болжээ. Тус бүс Хойд Солонгосын хувьд орлогын гол эх үүсвэр аж. Хоёр улсын өнөөгийн харилцаа ямар байгаа нь тодорхойгүй ч энэ хэлэлцээр цаашид хийгдэх олон хэлэлцээрийн эхлэл байж болох талтай ажээ.



Европын холбоо болон АНУ-ын дэлхийн хамгийн том худалдааны бүсийг байгуулах уулзалт, хурал болов. АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын газрын нууц мэдээлэл алдагдсан таагүй мэдээг үл харгалзан хоёр талын хөрөнгө оруулалтад учирч буй саад, бэрхшээлийг арилгахыг эрмэлзэж байгаа аж. Ингэснээр Атлантын далайгаар тээвэр зууч хийдэг компаниудын зардал буурах аж. Мөн хоёр гүрний хоорондох бүтээгдэхүүн, үйлчилгээнд ногдуулах шууд тариф сайжрах боломжтой юм.


Английн фунт стерлингийн ханш

ам.долларын эсрэг 1.49 болж буурсан нь сүүлийн гурван жилд хамгийн доод үзүүлэлт болжээ. Шалтгаан нь Английн Төвбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлж чадаагүй, АНУ-ын эдийн засаг сайжирч байгаатай холбоотой аж. АНУ-д ажил эрхлэлтийн тоо 195 мянгаар нэмэгдсэнээс хойш ам.долларын ханш нэмэгдэх болсон. Харин Английн хувьд энэ үзүүлэлт тааруухан байгаагийн зэрэгцээ бодлогын хүүгээ харьцангуй тогтвортой буюу 0.5 хувь дээр тогтоон барьж байна.

Грек 6.3 тэрбум еврогийн тусламж авах тал дээр өөдрөг байгаа аж. Евробүсийн сангийн сайд нар тус улсад дахин тусламж үзүүлэх талаар энэ сарын дундуур уулзахаар төлөвлөж буй. Учир нь Грекийн эдийн засаг өндийхгүй хэвээр

байгаа юм. Гэвч тодорхой дэвшил гарчээ. Тус улс ирэх наймдугаар сарын дунд үеэр доод тал нь 6.6 тэрбум еврогийн өр төлөхөөр болсон бөгөөд эдийн засгийн сэргэлт нь удаашрах хандлагатай байгаа аж.

Ойрхи Дорнодод тархаад буй MERS




амьсгалын замын вирусын халдварын улмаас дахин хоёр хүн амиа алджээ. Нийт 70 хүн халдвар авсан тохиолдол байгаагаас 43 нь нас барсан байна. Одоогоор уг вирус бүх нийтийг хамраагүй байгаа боловч нас барагсдын тоо, энэ вирусын талаарх мэдлэг хомс байгаа нь харанга

дэлдээд буй. Дахин хохирол учруулж, цаашилбал дэлхийн хэмжээнд үхлийн аюултай болохоос нь өмнө уг вирусын үүсэл гарлыг тодорхойлох онцгой уулзалт, хурлыг зохион байгуулахаар олон эрдэмтэн хамтран ажиллаж байна.

Германы экспорт өнгөрсөн тавдугаар сард 2.4 хувиар огцом буурч, харин импорт өмнөх сараас 0.5 хувиар өсч, 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин экспорт өнгөрсөн дөрөвдүгээр сард 1.4 хувиар өсч байжээ. Үүнээс шалтгаалан өнгөрсөн дөрөвдүгээр сард худалдааны илүүдэл 18 тэрбум евро байснаас өнгөрсөн тавдугаар сард 13.1 тэрбум евро болж буурчээ. Шинжээчид худалдааны илүүдлийг 17.6 тэрбум евро байна хэмээн тооцоолж байв. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



Шог зургийг А.Амарсайхан

ОНЦЛОХ

“ЭРЭЭН” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Б.ЭНХЦЭЦЭГ

Зүглүүлээд өгвөл замаа олоод явчихдаг аялал жуулчлалын салбар Монгол Улсын хувьд амьсгаатай төдий гэлдэрч яваа гэхэд хилсдэхгүй. Өнөөдөр аялал жуулчлалын салбар Монголын ДНБ-ий тав хүрэхгүй шахам хувийг эзэлж байгаа бол өндөр хөгжсөн дэлхийд танил орнуудад эдийн засгийн тулгуур салбар болчихсон нь ч бий. Тухайлбал, Итали улсын ДНБ-ий 69 хувийг үйлчилгээний салбар тэр дундаа аялал жуулчлал эзэлдэг бол Грек улсын ДНБ-ий 18, Испани 14.3, Турк 10, Франц 9.3 хувийг тус тус аялал жуулчлал бүрдүүлдэг байна. Гэвч эдгээр улс нь эдийн засгийн хувьд манай улсаас хэд дахин том бөгөөд жилд хүлээж авдаг жуулчны тоо нь 30 саяас дээш.

Соёл, спорт, аялал жуулчлалын яамны гаргасан судалгаагаар өнгөрсөн жил манай улсад зочилсон гаднын гийчдийн тоо 620 мянга гаруй байсан ба үүнээс 475 мянга нь жуулчны визтэй байж. Аялагчдын тоог өмнөх онтой харьцуулбал аялал жуулчлалын салбар ердөө дөрвөн хувиар өсчээ. Жилдээ 500 мянга шахам жуулчин Монгол Улсын хилийг давдаг ч тэдний дийлэнх нь Хятадын хууль бус ажилчид байдаг бол ердөө 100 мянга хүрэхгүй шахам нь жинхэнэ жуулчин гэх тооцоо бий. Засгийн газрын амны билгээр болдог бол хоёрхон жилийн дараа буюу 2015 он гэхэд Монголд ирэх жуулчдын тоо нэг саяд хүрэх ёстой. Гэвч тус өөдрөг төсөөлөл талаар болох таамаг бий. Өнгөрсөн арван жилд хагас сая

жуулчны өсөлт үзүүлж чадаагүй улс ирэх гурван жилд огцомдож нэг сая хүрэх нь эргэлзээтэйг өнгөрсөн жилийн өнгө гэрчилж буй. Дэлхийн эдийн засгийн чуулган энэ жилийн эхээр “Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар 2013 тайланг” гаргасан бөгөөд нийт 140 орныг аялал жуулчлалаа цаашид хөгжүүлэх чадвар, хүмүүсийг татах онцгой чанаруудаар нь уралдуулсан. Монгол Улсын хувьд тус жагсаалтын сүүл мушгисан 10 оронд багтжээ. Өөрөөр хэлбэл, манай улс жуулчдыг хажигладаг оронд тооцогдож байна. Энэ нь нэг талаас манай үйлчилгээний салбарын чанарыг харуулж буй. Аялал жуулчлалын салбарыг үйлчилгээ гэх ганц үгээр илэрхийлж болно. “Европын орнуудад ойролцоогоор 250 ам.доллараар тав хоног аялж байхад манай улсад ирж буй гийчид дунджаар 900-1800 ам.доллар төлдөг. Монгол Улс жуулчлахад зардал өндөр, үйлчилгээ доогуур, үзвэр ховор орон” хэмээн “Ар Монгол” компанийн гүйцэтгэх захирал В.Батзориг хэлж байна. Өөрөөр хэлбэл, манай улсын аялал жуулчлалын олон улсын зах зээл дээрх үнэ болоод үйлчилгээний өрсөлдөх чадвар доогуур байна гэсэн үг.

Өнгөрсөн хугацаанд яамдуудын хаяа дэрлэж, халааснаас халаас дамжиж ирсэн тус салбар энэ удаад Соёл, спортой дэр нэгтгэсэнд салбарынхан боломж гэж харж буй. Тэгвэл шинэ сайдтай шинэ яам өнгөрсөн хагас жилд юу хийсэн бэ. Салбарынхны зүгээс бодлого

тодорхойлогчийнхоо хийж буй ажлыг хэрхэн дүгнэж буй нь сонин. Товчхондоо тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг урьтал болгохоор шийдсэн яам өнгөрсөн хугацаанд холбогдох хуулиа дахин боловсруулах аялал жуулчлалын үйл явдлуудаар цагалбар гаргах, “Ай-Ти-Би Берлин-2015” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд түншлэх, “Go Nomadic & Experience Mongolia” гэсэн уриаг салбарынхнаар сонгуулж, Үлэг гүрвэлээ авчирсан тэргүүтэй ажлуудыг хийжээ. Ерөнхийдөө нүүдлийн соёлыг үз гэсэн уриатай, үлэг гүрвэлийн орон гэдэг эрээн аялал жуулчлалын имижтэй болчихоод байгаа.

Гэвч эцсийн үр дүнг нь тооцоолоход бэрх, зангидсан нэг бодлогогүй, олон тийшээ савчиж, зөрчилдсөн, том ярихаас цаашгүй байгааг салбарынхан шүүмжилж байна. Тэд нэн тэргүүнд үйл ажиллагаа явуулах таатай орчин, ажил, амьдрал тэтгэсэн бодлогыг хүсч буй. Тухайлбал, аялал жуулчлалын салбарын гандан буурдаггүй ганц брэнд Наадмаар энэ жил манай жуулчны компаниуд аялагчиддаа наадмын тасалбар худалдан авахын тулд урт дарааллаас гадна, компанийнхаа гэрчилгээний хуулбар, татвар төлсөн баримт, жуулчин бүрийн нэр, хаяг зэрэг чирэгдэл учруулсан шаардлагаар дарамталлаа. Мөн жуулчны компаниуд үйлчилгээний унаануудаа авто замын дугаарын хязгаарлалтад зохицуулж, хэрэглэх гэж ядаж байгаа. Түүнчлэн тусгай ▶

► хамгаалалттай газрын тоо жил бүр нэмэгдэж, нэвтрэх үнэ нь өснө. Хувийн хэвшлийнхний нуруун дээр явж ирсэн энэ салбарыг хөгжүүлнэ гэж амлчихаад наад захын зохицуулалт ч хийчихгүй байгаад чамлалттай хандах хүн цөөнгүй. “Энэ яамны ярьдаг асуудал нь хууль, үлэг гүрвэл хоёр. Хувийн хэвшлийнхнийг сонсож байгаа ч юм алга. Хийж буй ажил, бодлогыг нь нарийвчлаад харвал, бодит бус, хүний нүд хуурсан шинжтэй байна. Төр дэмжээд байгаа юм алга. Эхний ээлжинд бүгдээрээ

суугаад хэлэлцэх л хэрэгтэй байна” хэмээн “Нью жуулчин” компанийн ерөнхий захирал Ш.Нэргүй хэлсэн.

Манай компаниуд нэг үеэ бодвол олон улсын мэргэжил нэгтгүүдтэйгээ харилцаа холбоо сайтай ажиллах болсон. Бусад орны аялал жуулчлалын компаниуд ч манайд жуулчдыг олноор нь өгье гэдэг. Гэвч Монгол “масс” жуулчин авах нөхцөл хязгаарлагдмал. Тухайлбал, дэлхийд өргөн дэлгэрсэн байгууллагын ажилчиддаа үзүүлдэг урамшууллын аяллаар нэг удаадаа 50-иас дээш

хүнтэй групп хүлээн авах боломжтой ч тэднийг нэг дор байрлуулах байр сав, аяга таваг манайд цөөддөг. Нөгөө талаас тусгай сонирлын үнэтэй аялал жуулчлалыг хөгжүүлье гэх боловч бидэнд тэдний дээд зэрэглэлийн хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ бий юу. Дэд бүтэц гэдэг аялал жуулчлалын мөнхийн арсалт дайсан байсаар ирлээ. Хэдийгээр хувийн хэвшлийнхэн яамны ажлыг үгүйсгээгүй ч саалиа бэлдэхээр саваа бэлдэхэд түлхүү анхаарах нь зүйтэйг учирлаж байна. ■



Фотог Б.Бямба-Очир

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

МЭДЛЭГТ СУУРИЛСАН БАЙХ ТУСМАА ҮҮРГЭВЧТЭЙ АЯЛАГЧИД ЦӨӨРНӨ



Фотог Б.Бямба-Очир

Соёл, спорт аялал жуулчлалын сайд
Ц.Оюунгэрэлтэй ярилцлаа.

-Аялал жуулчлалын салбар нэг яамны бөөрөнд наалдаж, нөгөө яамны халаасанд багтаж өдийг хүрлээ гэх шүүмжлэл салбарынхны дунд нэлээд байсан. Тэгвэл тус салбар өнөөдөр соёл, спорттой хэрхэн уялдаж цаашдын хөгжлөө тодорхойлж байна вэ?

-Соёл, спорттойгоо уялдах эхний зангилаа энэ жилийн хувьд дөнгөж эхэлж байна. Манай яамнаас гаргасан цагалбарт соёл, спортын арга хэмжээнүүд багтсан. Нөгөө талаас спорт нь зөвхөн биеийн тамирын бус аялал жуулчлалыг хөгжүүлэх талбар. Монгол цаашдаа спорт аялал жуулчлалын томоохон төв болно гэж бид үзэж байгаа. Учир нь цар хүрээ өргөн спортын арга хэмжээ, бэлтгэлүүд манай улсад зохион байгуулагдах боломжтой. Далайн түвшнээс дээш 1000 ба түүнээс дээш метрийн өндөрт өргөгдсөн, хуурай уур амьсгалтай зэрэг онцлог нь бэлтгэл базаах сайн суурь болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, спортын бэлтгэлийн сайн төвүүдийг байгуулж чадвал манай спортын амжилт өсөөд зогсохгүй Монгол өөрөө бэлтгэлийн төв болох ирээдүйтэй.

Соёлын асар их өв сантай орны хувьд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой орон. Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэе гэвэл соёл гэдэг шавхагдашгүй уурхайг илүү нээх ёстой. Соёл, спортод оруулж буй хөрөнгө оруулалт бүр аялал жуулчлалаа дэмжиж байгаа.

-Аялал жуулчлалын брэндинг дээр салбарынхны зүгээс түлхүү анхаарч ажиллаж буй. Тэгвэл энэ тал дээр гаднын мэргэжилтнүүдтэй хамтарч байгаа юу? Гаднын орнуудад мэргэжлийн байгууллагын туслалцаа авах туршлага байдаг.

-Үнэ өртгийн хувьд гаднын байгууллага, мэргэжилтнүүд нэлээд өндөр. Манай яаманд олгодог төсөв их бага. Тиймээс өндөр боловсролтой монгол иргэдийнхээ хүч хөдөлмөр, оюунд тулгуурлана. Олон улсын мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч хамтарч байгаа тал бий. Тодорхой компани гэхээсээ ▶

► илүү аялал жуулчлалын экспортыг нэмэгдүүлэхэд тусгайлан мөнгө зарцуулдаг төрийн байгууллагуудтай хамтарч байна. Нидерландын Засгийн газрын дэргэд аялал жуулчлалыг экспортлох талаар зөвлөгөө өгдөг байгууллагатай манай яам гэрээгээр хамтран ажиллаж байна. Үүгээр дамжуулан Европын зах зээлд хандсан ямар үйлчилгээ гаргаж болох компаниудаа хэрхэн бэлдэх чиглэлээр өмнө нь эхлүүлсэн хамтын ажиллагааг үргэлжлүүлж байна. Мөн олон улсын зах зээлд хүчтэй гарч ирэхийн тулд ИТВ олон улсын аялал жуулчлалын яармагт гол түнш орноор оролцох шийдвэрийг Засгийн газар гаргасан. Монгол Улсыг Германы аялал жуулчлалын ИТВ гэх байгууллагаар дамжуулан олон улсад сурталчилна гэсэн үг. Тус байгууллагын мэргэжлийн маркетингийн алба Монголыг сурталчлах үүрэг хүлээж байгаа юм. Ерөнхийдөө олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах замаар сурталчилгаа хийж байна.

-Яамны тайлангаас үзэхэд аялал жуулчлал өмнөх онд ердөө дөрвөн хувиар өссөн байна. Өнгөрсөн дөрвөн жилд ч төдийлэн энэ үзүүлэлт өндийгөөгүй. Тэгвэл 2015 онд нэг сая жуулчин хүлээн авна гэх тоо “газардах” найдлага байна уу?

-Манай голлох зах зээл Европт эдийн засгийн хямрал болсонтой шууд холбоотой байсан. Бид сурталчилгаагаа өнөөдөр эрс нэмэгдүүлсэн. Ингэсний дүнд л сая жуулчин авна. Харилцаагаа өргөтгөж, холболтыг сайжруулах нь чухал байна. Аялал жуулчлалын санд нэг тэрбум төгрөгөөс илүүг өмнө нь төсөвлөж үзээгүй. Сургууль, цэцэрлэг барьдаг мөнгөөр л бүхэл бүтэн салбарыг авч явж байлаа. Германы ИТВ яармагт оролцоход гурван тэрбумын өртөг яригдана. Энэ нь аялал жуулчлалд оруулж буй хөрөнгө оруулалт доод тал нь дөрөв дахин нэмэгдэж байгааг харуулна. Цаашдаа хөрөнгө оруулалт ч нэмэгдэнэ. 2014-2015 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хэд, хэдэн аялал жуулчлалын цогцолборыг барих саналыг оруулахаар төлөвлөж байна. Дэд бүтцэд хөрөнгө оруулах нь сая жуулчин авах хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

-“National

Geographic”

нийгэмлэгийн сэтгүүлтэй 300 сая төгрөгөөр хамтран ажиллах гэрээ байгуулсан гэж байсан. Тэгвэл тус сэтгүүл манай улсыг хэрхэн сурталчлах вэ ?

-Монголд ирэхийг хүсэгчдийн сонирхлыг өдөөхүйц нийтлэл, зураг мөн үйлчилгээ санал болгогч компаниудыг сурталчлахаар “National Geographic” Travel Mongolia нэрийн сэтгүүл гаргахаар төлөвлөж байна. Ийм нэрийн сэтгүүл гаргасан 16 дахь орон Монгол боллоо. Гэрээний хоёр жилийн хугацаанд тус сэтгүүлийн уншигчдад эх орноо бүрэн танилцуулахыг зорьж буй. Одоогоор цэвэр сурталчилгааны зорилгоор гэрээ байгуулсан тул гаднын аялал жуулчлалын компаниуд, олон улсын зочид буудал, агаарын тээврийн компаниуд тэргүүтэй аялал жуулчлалын сувгуудаар сэтгүүлийг үнэгүй тарааж байна. Хэрэв цаашид тус сэтгүүлийг захиалж унших хүмүүсийн тоо олширвол, сэтгүүл өөрөө өөрийгөө аваад явах боломжтой болох юм.

-Тоо бус чанарыг барьж ажиллаж гэсэн саналыг салбарынхан дундаа нэлээд дэмждэг. Үнэтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг яамны зүгээс хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ?

-Аялал жуулчлалын салбар хэрхэн өөрөө өөрийгөө унагааж буйг бид бүгдээрээ хардаг. Тэрэлжид үйл ажиллагаа нь ижилхэн баазууд олон байгаа бөгөөд жуулчнаа урьтаж авахын тулд уралдаж бүтээгдэхүүний үнээ унагаадаг шүү дээ. Тиймээс бидний зүгээс жуулчны баазуудад шувуу, үлэг гүрвэл, спорт, соёл зэрэг чиглэл, сонирхлоо дагнаач гэсэн саналыг гаргасан. Үүнийг ч хэрэгжүүлээд явж буй баазууд бий. Урьд нь баазууд зөвхөн манаач, тогооч, үйлчлэгч хөлсөлдөг байсан бол өнөөдөр тусгай сонирхлоо тодорхойлсноор дасгалжуулагч, урлагийн мэргэжилтэн, шувуу судлаач зэрэг хүмүүсийг ажиллуулж байна. Ингээд ирэхээр аялагчдыг сонирхож буй чиглэлд нь авч явж чаддаг төлбөр, ашиг өндөртэй аялал жуулчлал руу хувирах бололцоотой юм.

-Үүргэвчтэй аялагчдаас /Backpackers/ татгалзаж, зөвхөн жуулчны компаниар дамжиж буй аялагчдыг хилээрээ давуулдаг орнууд байдаг.

Аялал жуулчлалаа хөгжүүлэх гэж байгаа орны хувьд мөнгийг нь бодвол тэднээс татгалзах ёстой юу?

-Үүргэвчтэй аялагчдыг хөөж гаргадаг орон болох нь их бүдүүлдэг асуудал. Үүргэвчтэй аялагч бус жинхэнэ аялагч байсан ч болоосой гэтэл нь манай аялал жуулчлал хөгжих ёстой. Үүргэвчтэй аялагч байснаар ямар ихийг алдаж байгааг мэдэртэл нь бид хөгжих ёстой. Мэдлэгт суурилсан байх тусмаа тэдний тоог цөөрүүлж чадна. Тусгай сонирхол гэж үлгээд байгаагийн учир энэ юм шүү дээ.

-Аялал жуулчлалын салбарынхны толгойны өвчин бол хүний нөөцийн асуудал. Энд хэр анхаарч ажиллаж байна?

-Хөтчийн сургалтыг байнга хийж байна. Үүний зэрэгцээ их дээд сургуулиудтай хамтарч ажиллах шаардлага нэн тэргүүнд тавигдаж байгаа. Аялал жуулчлалын менежер гэдэг ерөнхий мэргэжлээр сургаад байгаа болохоос тусгай сонирхлын аялал жуулчлалаар мэргэшүүлсэн нь бага. Тиймээс манай яам аялал жуулчлалын сургалтын хөтөлбөрийг боловсруулахад хамтарч ажиллахаас өөр аргагүй байна. Эхний ээлжинд шувууны аялал жуулчлалыг яаж хийх вэ гэдгийг сургахаар Турк улс руу найман хөтчийг явуулахаар сонгосон. Мөн шувуу сонирхогчдын зах зээл, үйлчилгээ нь юу байх талаар зөвлөгөө өгөх хүсэлтийг Английн хатан хааны ивээлд байдаг шувуу сонирхогчдын холбоонд тавьсан. Боловсон хүчнээ олон улсын түвшинд хүргэх үүднээс мэргэжилтнүүд урих ажлыг зохион байгуулж байна.

-Жижиг зах зээл дээр аялал жуулчлалын олон компанийн зөвшөөрлийг цуцалж, дахин стандартчилах асуудлыг хувийн хэвшлийнхэн өөрсдөө тавьдаг. Тэгвэл энэ байдал хэзээ цэгцрэх вэ?

-Өнөөгийн нөхцөлд компаниуддаа хэт хатуу шаардлага тавих болоогүй. Төрийн дэмжлэггүйгээр аялал жуулчлалд өөрсдөө хөрөнгө оруулж, жуулчдаа авчирч, хүнээ бэлдэж ажиллуулдаг одоогийн нөхцөлд төр хэт өндөр шаардлага тавибал өсөж буй зах зээлээ унагачих магадлалтай. Харин орон нутгийн ►

оролцоог нэмэгдүүлж, нэг талаас орон нутгийнхан аялал жуулчлалын бизнесийг, аялал жуулчлалынхан орон нутгийн соёлыг ойлгож бие биенээ хүндлэх тал дээр дэмжиж хамтрах юм. Стандартыг тогтоож өгнө. Гэхдээ стандартууд дундаа хамгийн сайн нь орон нутагтай хамтарч ажиллах чадвар. Орон нутгийн бүтээгдэхүүнийг худалдаж авдаг, татвараа төлдөг, орлого оруулдаг, байгальд ээлтэй компани л хамгийн сайн нь. Орон нутгаа тэтгэдэг байх нь аялал жуулчлалын бизнесийн ач холбогдол.

Стандартыг тэгшитгэхээс өмнө тавих шаардлагуудаа илүү тодорхой болгох ёстой. Дараа нь энэ асуудлыг ярина. Эхний ээлжинд тусгай сонирхлоор дагна, байгальд ээлтэй бай, аялал жуулчлалд хэрэгтэй бүс нутгийг нийлж хамгаал, орон нутагтаа ээлтэй компани байгаа гэдэг шаардлагуудыг тавьж байгаа.

-Аялал жуулчлалын тогтвортой хөгжил бүсчлэлийн асуудлыг өнөөдөр нэлээд ярьж байгаа.

-Тогтвортой хөгжихийн тулд нэн тэргүүнд аялал жуулчлалынхаа газар нутгийг хамгаалж сурах хэрэгтэй. Газар нутаггүй бол аялал жуулчлал байхгүй. Бид орон нутгийн засаг захиргаатай аялал жуулчлалын орчны бүсийн дүрэм баримталж эхлэх хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

-Танай салбартай холбоотой 10 гаруй хуулийн төсөл юу болж байна вэ?

-Аялал жуулчлалын салбартай холбоотой хоёр хуулийн концепцийг Хууль зүйн яаманд хүргэсэн ч хоёр хуулиа нэгтгээд нэг хууль болго гэсэн шаардлага ирсэн. Тиймээс бид нэг хууль болгож байна. Өмнөх санал нь Аялал жуулчлалын орчны бүсийн тухай хууль, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга байгаа. Нэгтгэж буй хуульдаа бид аялал жуулчлалын үйлчилгээний тусгай сонирхлыг яаж хийх, аялал жуулчлалын үндэсний төвийн үүрэг, аялал жуулчлалын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдэх, жуулчны компаниудын гадагшаа харьцах сувгуудыг яаж зохион байгуулах вэ зэрэг асуудлыг оруулж байгаа. Хамгийн гол нь орчны бүсээ хэрхэн төлөвлөж, тодорхойлох, хэрхэн зохицуулах талаар заалтууд тусгаж өгнө. Бид энэ хуулийг намрын чуулганд оруулж батлуулахаар төлөвлөж байна. ■

ҮЗЭЛ БОДОЛ

БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ



Д.Гансүх (Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгааны төвийн тэргүүн)

Хүний оюун ухаанаас урган гарах санаа сэдэл, үзэл бодол, бүтээл туурвил, орчин үеийн мэдээлэл харилцааны дэвшилтэт технологид тулгуурлан хөгжиж байгаа бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь зөвхөн өндөр хөгжилтэй орнуудын бодлого биш юм. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухааны байгууллага НҮБ-ын Худалдаа, үйлчилгээний хөгжлийн бага хурал, НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага болон Дэлхийн оюуны өмчийн, Дэлхийн хөдөлмөрийн зэрэг олон улсын нэр хүнд бүхий байгууллагууд дэлхийн хөгжлийн чиг хандлагыг ойлгож, анхаарч, энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бүрэн дэмжиж байна.

Бүтээлч үйлдвэрлэл нь улс оронд бүтээлч эдийн засгийг хөгжүүлдэг.

Бүтээлч үйлдвэрлэлийг хөдөлгөгч хүч нь

•Нэгдүгээрт: технологи (мультимедиа, орчин үеийн холбоо, дижитал технологи, интернэт),

•Хоёрдугаарт: зах зээлийн эрэлт хэрэгцээ (хүн амын орлого нэмэгдэх, соёлын хэрэгцээний төлөв өөрчлөгдсөн, хэрэглэгч өөрөө хамтрагч-бүтээгч болсон),

•Гуравдугаарт: аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага (соёлын жуулчдын тоо нэмэгдэж, тэд бүтээлч жуулчин болж байгаа) тус тус юм.

Монгол Улсын хувьд өнгөрсөн 2012 оны байдлаар 476 мянга гаруй жуулчин хүлээн авсан нь харьцангуй “даруухан” тоо ч, нийтийг хамарсан масс аяллууд хөгжөөгүй нь бид энд аялал жуулчлалын оновчтой хэлбэр, төрлүүдээ тогтоож, бодлогоор удирдах боломжийг өгч байна. ►

БҮТЭЭЛЧ ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засагт хувь нэмэр оруулах мэдлэгт тулгуурласан эдийн засгийн

үйл ажиллагааны дүнд бий болох салбар дундын хамтарсан бүтээлийн нэгдэл.

БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

нь биет бүтээгдэхүүн ба биет бус үйлчилгээ Бүтээлч агуулга, эдийн засгийн үнэ цэнэ ба зах зээлийн зорилготой юм



► Дэлхийн эдийн засгийн форум нь “Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар”-ын судалгааг жил бүр явуулж, энэхүү тайлангаа дэлхийн улсуудын төр, засаг болон бизнесийн байгууллагууд аялал жуулчлалын өрсөлдөх чадвараа сайжруулж, хөгжлийн стратегиа тодорхойлох гол баримт бичгээ болгон ашиглаж байна.

Энэ нь нэгдүгээрт, аялал жуулчлалын зохицуулалт, эрх зүй, хоёрдугаарт, аялал жуулчлалын бизнесийн орчин ба дэд бүтэц, гуравдугаарт, хүн ба байгаль, соёлын нөөц гэсэн бүлгүүдэд хуваагдах 14 чиглэлээр нийт 71 үзүүлэлтээр дэлхийн улс орнуудыг эрэмблэн жагсаадаг индекс юм.

Монгол Улс 2013 оны энэхүү тайланд дэлхийн 140 улс орнуудаас 99 дүгээр байранд орж, 2011 оны 139 орноос 101-д орсон үзүүлэлтээ хоёр байраар урагшлуулсан байна. Мөн Ази, Номхон далайн 25 орноос 19 дүгээр байрт багтжээ. Тайлангийн мэдээллээр манайх соёлын нөөцийн үнэлгээгээр 66 дугаарт жагсаж байгаа ч “бүтээлч үйлдвэрлэлийн экспорт” үзүүлэлтээр 110 дугаарт орсон нь бид өөрийн соёлын өвд тулгуурлах бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн ямар түвшинд явж буйг харуулна.

Өнгөрсөн онд Аялал жуулчлалын үндэсний төвөөс олон улсын жуулчдын дунд явуулсан судалгаанаас үзэхэд, гадаадын жуулчдын хувьд Монгол Улсыг сонгосон гол шалтгаан нь

1. Нүүдлийн соёл, түүх,
2. Монголын байгаль
3. Адал явдалт аялал байв

Эдгээр шалтгааныг үндэслэн аялал жуулчлалын оновчтой төрлийг тогтоохыг зоривол, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улс нь тусгай сонирхлын аялал жуулчлалын газар нутаг байна гэсэн ерөнхий дүр зураг харагдаж байна. Мөн судалгаанаас үзэхэд, нүүдлийн соёлоо хадгалсан байдал, орон нутгийнхны найрсаг зочломтгой зан, аяллын үеийн хамгийн өндөр үнэлгээг авчээ.

Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгож, брэнд хөгжүүлэхэд соёлын бүтээгдэхүүнгүйгээр төсөөлөхийн аргагүй. Энд соёл урлагийн шилдэг бүтээл, туурвилуудаас олон улсын болон дотоодын аялал жуулчлалын зах зээлд нэгэнт танигдсан нүүдэлчний ахуй соёл, Үндэсний их баяр-наадам, монголчуудын уламжлалт Цагаан сар, Эзэн Чингисийн хөшөө цогцолбор зэрэг жишээг дурьдаж болно. Мөн манай бүтээлч уран бүтээлчид, зохион байгуулагчид, хөрөнгө оруулагчид хамтран одоо боловсруулан буй “Үлэг гүрвэлийн байгалийн музей”, “Хархорин 13-р зуун”, “Их Майдар” гэх мэт төр, хувийн хэвшлийн төсөл, хөтөлбөрүүд ч Монголын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийн цаашдын хөгжилд томоохон түлхэц болох нь дамжиггүй юм.

Монгол Улсын бүтээлч үйлдвэрлэлийн цаашдын хөгжил нь хамрах салбарууд, түүний дотор соёл урлаг, аялал жуулчлал, боловсролын салбарын стратегийн бодлогоос шууд хамааралтай байна.

Соёл урлаг-аялал жуулчлалын нэгдэл нь бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, олон улсын дотоодын зах зээлийн брэнд хөгжүүлэх, эрэлт хэрэгцээг хангах суурь болно.

Дэлхий даяар олон улсын аялал жуулчлалын дундаж өсөлт 4-6 хувьтай байдаг бол бүтээлч үйлдвэрлэлийг бүрдүүлэгч цөм болсон соёлын аялал жуулчлалын жилийн дундаж өсөлт 15 хувь орчим байна. Цаашид жуулчид өөрсдөө оролцож, хамтран гүйцэтгэж, оюун ухаанаа тэлж, улмаар дэлхийн иргэний соёлыг даяаршуулах үйл явц эрчимжиж, уламжлалт соёлын аялал жуулчлал нь бүтээлч соёлын аялал жуулчлал болон хөгжих хандлагатай.

Бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулж, аялал жуулчлалын салбарын зах зээлийн эрэлт хэрэгцээ, өсөлттэй уялдуулан хөгжүүлэхэд байгаа юм.

- Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шинэ арга хэлбэрүүдийг нээж, бодит боломжуудыг татах талаар бизнесийн хүрээнийхэнтэй хамтран ажиллах
- Аж ахуй эрхлэн хөтлөх боловсрол, ур чадвар болон бизнес сэтгэлгээ бүтээлч үйлдвэрлэлийн салбарт дутагдаж байна.
- Институцийн оновчтой механизм үгүйлэгдэж байна.
- Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын статистик, сурталчилгаа-судалгаа дутагдалтай.
- Оюуны өмчийн хамгаалалт ба үнэлгээ зэрэг асуудал байгааг цаашид шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Хэдийгээр улс орны аялал жуулчлалын өв нөөц, бүтээгдэхүүн нь жуулчдыг татах гол нөхцөлүүд мөн ч байгаль, соёлын бодит нөөц, бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын зах зээлд хүргэх, менежмент, маркетингийг хийж, үнэ цэнийг нэмэгдүүлэх нь түүнээс дутахгүй чухал. Иймээс ч улам бүр өсч буй өрсөлдөөнд амжилт олохын тулд зөвхөн байгаль соёлын өв, нөөцөнд бус хүний бүтээлч хөдөлмөр, шинжлэх ухаан, технологи, инновацид тулгуурлаж бүтээлч аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлага урган гарч байгаа юм. ■



